



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/179

Мандалговь

Зохион байгуулалтын арга
хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой Онцгой комиссын 2020 оны 25 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан жагсаал цуглаан, нийтийг хамарсан спортын арга хэмжээ, цахим тоглоомын газар, диско баарны үйл ажиллагааг 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд хориглосугай.

Хоёр. Дээр зааснаас бусад бүх төрлийн тоглоомын газар, баар, караоке, биллиард, шашин, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагааг шинэ коронавирус (КОВИД-19)-өөс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар зөвлөмжийг мөрдлөг болгон халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй.

Гурав. Захирамжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших) болон холбогдох байгууллага, аж ахуй нэгжийн дарга, удирдлага, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010473